

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 28 дахь дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын “Судалгаа” хэсэгтээ Их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийнхээ дагуу ажил эрхлэхгүй байгаад нөлөөлж буй хүн ам зүй, нийгэм эдийн засаг болон бусад хүчин зүйлсийг тодорхойлсон ахьсан түвшний шинжилгээний үр дүнг танилцуулж байна. Эдийн засгийн өсөлт ба тэгш бус байдлын хамаарлын гүнзгийрүүлсэн дүн шинжилгээгээр Монголын өнөөгийн эдийн засгийн өсөлтийг хангахад хүн бүр оролцож чадсан эсэх, өсөлтийн үр шимийг тэгш хүртэж байгаа эсэхийг тодорхойлсон үр дүнтэй танилцаарай. Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн насны статистик тархалт, анхны хүүхдээ төрүүлэх насанд тухайн эмэгтэйн шинж байдал хэрхэн нөлөөлдгийг тохиох хугацааны шинжилгээний аргаар үнэлсэн үр дүнг уншигч танд танилцуулж байна. Хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлтөөс улбаалан анхан болон суурь боловсролын үйлчилгээний хэрэгцээ, хэтийн төлөв байдлыг тооцоолон тодорхойлсон судалгааны үр дүнтэй танилцах боломжтой.

“Үзэл бодол” хэсэгт иргэдийн цалин, хөдөлмөрийн орлогоос бүрдүүлсэн нийгмийн даатгалын сангийн менежментийг нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар үнэлэх боломж байгаа талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

“English” хэсэгтээ ажиллах хүчний үндэсний хэмжээний түүвэр судалгааны тоон мэдээллийг ашиглан Монголын залуучуудын эдийн засгийн идэвхгүй байгаа ажил хийгээгүй болон сургуульд суралцаагүй байхад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн ялгаатай байдлыг олон хүчин зүйлийн шинжилгээгээр тодорхойлсон дүн шинжилгээнээс гарсан үр дүнтэй танилцаарай. Олон шатлалт урт хугацааны шинжилгээний аргаар сургалтын үр өгөөжийг үнэлсэн ахьсан түвшний дүн шинжилгээний үр дүнг танилцуулж байна. Сошиал медиаг боловсролд ашиглах боломж, их дээд сургуулийн багш нар болон хөндлөнгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн санал бодлыг илэрхийлсэн чанарын судалгааны үр дүнг танилцуулна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ